

СОЁЛ

**МИЛАЙРАБЫН НАМТРЫН  
ЗАРИМ ОРЧУУЛГЫН  
ТУХАЙД**

Д. ЦЭДЭВ

Бидэнд нэгэнтээ мэдэгдэн монголчуудын дотор судар болон аман яриагаар дамжин хүрч ирсэн Төвдийн яруу найрагч Милайрабын намтар гэдэг судар түүний бүтэц, товч агуулга, монголчууд хэрхэн судлаж, яаж яаж орчуулж ирсэн уламжлал, анх орчуулах болсон түүхэн нөхцөл зэрэг асуудал судлаачдын анхаарлыг татсаар ирлээ. Яруу найрагчийн амьдран байсан XI зууны эхэн хагаст зохиогдсон төвд намтарт дурдсанаар Милайраб «Усан эр луу жилийн намрын дунд сарын «хаан» нэрт од буух өдөр төрсөн»<sup>1</sup> гэжээ. Энэ мэдээгээр бол 1052 онд төрж, 1135 онд 84 настай модон туулай жил нас баржээ.

Уг судрын дэлгэрэнгүй нэр нь «Егүзэрийн эрхэт баялаг дээд богд Милайрабын намтар, хамгийг мэдэгчийн мөрийг үзүүлэхүй оршсон болой», хураангуй нэр нь «Милын намтар». Энэ судар Их хүрээний Дашлхүнбэ хийд мөн Далай гүний хошуу зэрэг хэд хэдэн модон бараар олшруулагдсан болтойгоос гадна бээжин бар, бас гар бичмэлээр тархаж байсан үзэгддэг.

Милын намтрыг өрнө зүгийн уншигчдийн хүртээлд хүргэсэн хүн Кази Даваасамдуб англи хэлээр орчуулсан, дараа нь Еванс Вентын оршил, товч танилцуулгатай хэд хэдэн удаа хэвлэжээ.

Милын намтрыг монгол хэлээр хэзээ хэдүйд, хэн орчуулсан тухай Ш, Дамдин «Алтан дэвтэр»-т бичихдээ: Хөх хотын бандида ширээт гүүш Цорж «Билэгбрамидын 3 боть, Милын намтар, Милын буман дуулал»-ыг орчуулав<sup>2</sup> гэжээ.

Уг зохиолын монгол орчуулгын төгсгөлийн үгэнд:

«Буянт Чин тайху нэрт  
Гэгээн оюун билэг сайтар төгссөн  
Хэлшгүй чанарыг огоод ухагсан  
Хэлбэрэхүй үгүй номын үйлийг хийсэн  
Хэтэрхий цогт Хунтайж хэмээн алдаршсан  
Эх хөвгүүн хоёр чин сэтгэлээр  
Эдгүүлж орчуул хэмээн дурдсанаар...»<sup>3</sup> гэжээ.

Энэхүү зохиолыг орчуулах болсон түүхэн шалтгаан, Чин тайху чухам юуны учир эрхэмлэн хүсэж, онцлон орчуулах шаардлагатай гэж үзэх болов гэдэг нь бидэнд сонирхолтой билээ.

Уг зохиолын бичсэн арга нь туйлын идэвхитэй зарчмыг баримтлан бичсэн ахул Цогт тайжийг манжийг эсэргүүцсэн тэмцэлдээ шантралгүй чин зориг, сэтгэлийн хатуужил суулгах, туйлын идэвхитэйн зарчмаар хүмүүжүүлэх нь тухайн үеийн цорын ганц зам хэмээн нэгэн үзүүрт төвлөрсөн сэтгэлийг барин, хатуу зорилгот чиглэсэн болохыг төгсгөлийн үг батлах баримт болно.

Бидний өгүүлэн буй Милын намтрыг бичгийн хэлээр орчуулан барлаж байснаас гадна монголчуудын дотор сударын аман орчуулгаар

<sup>1</sup> Милын намтар 10а тал, Бээжин бар, төвд эх судар

<sup>2</sup> Ш. Дамдин. «Алтан дэвтэр» 78-р тал, Хүрээ бар.

<sup>3</sup> Гүүш цоржийн орчуулга. «Милын намтар» 234-р тал Буриад бар.

уламжлан авч өгүүлэн хэлэлцэж, сударын зохист аялгууны аман орчуулга бий болтлоо хөгжиж ирсэн мэдээг дурдаад, бичгийн хэлний орчуулга, аман орчуулга хоёрын хооронд юу юу нь зөрөөтэй, юу юу нь дүйж буйг харуулан сударын аман орчуулга хаана хаана, хэн хэн орчуулж байсныг ялдамд дурдая.

Хуучин Говь түшээ вангийн (одоогийн Өмнөговь) хошуу «Бага модтын хийд»-ийн Цорж Сэвжид хэмээхүй «Милын намтар»-ыг маш сайхан яруу аялгуулан, үг найруулга яруу, утга илт, маш сонсголт эгшиглэн унших байдалд таацалдсан, үгийн утга санааг уужим дэлгэр, хэн хүний сэтгэлд урган буухуйц сайхан тогтоцтой орчуулдаг хүн байсан ажээ. Энэ орчуулга Ванчиндорж цоржид уламжлан дамжсаар түүний шавь тус Гандан хийдийн цорж байсан Ёндон гуайд үлдэж ирсэн. Бас өөр нэгэн орчуулга байдаг. Энэ нь эрдэнэ дүүрэгч вангийн (одоогийн Хөвсгөл аймгийн нутаг) Ар гөрөөчийн хийдийн Лигшид гавж хэмээхүй бөгөөд тэрээр «Милын намтар»-ыг мөн л гайхам уншдаг, тогтсон нарийн орчуулгатай хүн байснаас Дашням агсан Ар гөрөөчийн хийдэд Удганы хүрээнээс очиж 3 сар сууж уг орчуулгыг заалган авч хүрээндээ буцаж ирсэн гэж ярьж байснаас асууж, энэ 2 орчуулгыг харьцуулан үзэхэд хоорондоо их сайхан дүйдэг, илүү дутуу үггүй, өгүүлбэр хэм тэгш, утга тодорхой, монгол хүний сэтгэхүйн үүднээс нарийвчлан боловсруулсан байдал нь төвд хэлний үг өгүүлбэрийг дагаагүй орчуулсаны нотолгоо болох нь үнэнтэй.

Ингэхэд сударын бичгийн хэлний бат уламжлал нь аман орчуулгад тусгалаа олж, аман орчуулга бичгийн хэлний орчуулгад нөлөөлөн бие биеэ шүтэлцэн, нөхөн тэтгэж баяжуулан чадсанаараа сонин өвөрмөц орчуулга гарчээ гэх бүрэн үндэстэй юм.

Одоо бидний өгүүлж буй Милын намтарын Мөргөлийн хэсэг 12 бүлэгтэй нь «бурханы 12 зохионгуйд» дүйцүүлсэн бөгөөд харин бичсэн байдлыг ажиглан үзэхэд Энэтхэгээс Төвд оронд тогтсон зохист аялгууны яруу найргийн бат уламжлалт ёгт нэрийг түгээмэл хэрэглэн буддийн гүн ухааны бүхэл бүтэн ухагдахуун категорийг хураангуйлан ёгт нэрэнд шингээж, утга агуулга, гүн гүнзгий бодол санааг оновчтой яруу тодорхой илэрхийлэн гаргажээ.

Бидний өгүүлэн буй зохиолд байгаа ёгт нэр гэж чухам юуг хэлдэг, Ямар утга санааг илэрхийлдэг, хэрэглэх аргын талаас зарим заримыг тайлбарлаж болно. Жишээ нь:

— Хөх хотын Ширээт гүүшийн орчуулгад<sup>4</sup> «чүзэн»-г «усан баригч» гэж орчуулсаны «чү» нь ус, «зэн» нь баригч, энэ хоёрыг хослон «усан баригч» гэж орчуулсан бөгөөд «усан баригч» гэж чухам юуг хэлдэг вэ? гэвэл үүлийн нэр.

«Лэг» гэж гар «гар»-ыг 2-ын тооны утгаар илэрхийлдэг, «ро» үгчлэн орчуулбал «амт», утга нь 6-н тооны нэр, 6 зүйлийн амт байдаг тийм учраас 6-г илтгэдэг, энд харин 6 зүйлийн амьтан гэсэн утгаар авчээ.

«Дүй» үгчилбэл «цаг», 4 тооны нэр, энд «жи, най дүй» гэснээс «жи» нь «гарах, гарал», «най»-нь орон «дүй» 4, ингэхэд «төрлийн орон дөрөв» гэсэн утгатай дээрх 6 зүйлийн амьтан энэ 4-өөс төрөх ажээ.

Хөх хотын бандида ширээт гүүш Цорж «Милын намтар» нь Төвд хар ярианы үгээр жирийн өглөгийн эзэн, гөрөөчин, тариачин эгэл жирийн хүнд зориулагдсан нутгийн аялгуу, өвөрмөц хэллэг, ёгт үг, адилт гал, зүйрлэл, зүйр цэцэн үг мэтийг өргөн хэрэглэж байсан нь орчуулагч

<sup>4</sup> Хөх хотын гүүш., «Монгол Милын намтар» 1а тал, Буриад бар.

хүнд аргагүй бэрхшээл учруулж байсныг дурдаад зарим хэцүү нэр зүйлийг орхигдуулсан гэж өгүүлсэн байдаг.

Сайхь өгүүлэн буй «Милын намтар»-ын дотроос тус 2 орчуулгад аль үгийг хэн яаж орчуулж, аль орчуулга нь илүү ойлгоцтой, ухаарахад санаа төгс төгөлдөр, утга яруу болохуйг үзүүлэх зорилгоор монгол бичгийн хэлээр орчуулсан байдал, сударын аман орчуулга хоёроос зарим нэгэн өгүүлбэрийн орчуулгыг зэрэгцүүлэн үзье,

— Хөх хотын ширээт гүүшийн орчуулгад: «Номун биет тэнгэрийн мөрийн мунхагын усан баригчийн язгуураас хагацсан өнгөт бие бөгөөд өдөр шөнийн итгэл инү шумнасан усан рахул-и язгуураас ангижран үйл сүүн ухаан өршөөнгүй хязгаалалгүй гилбэлүүн бүхий өлзийт гэрлийн бэлчигсэнээр» гэжээ.

— Сударын аман орчуулгад:

«Номын бие огторгуй, ухамсаргүйн үүлэн эртэд ангижирсан төвд дүрс бие хоёр наран, саран итгэл дөрвөн шумнасын рахул ёзоороос хагацсан үйлс, айлдал энэрэлийн гэгээн гэрлийг цацрааж хязгаарлашгүй цогийг бадруулсан тул ... гэжээ.

Дээрх 2 орчуулгаас харьцуулахад төвд эх сударт байгаа «лха лам» гэдгийг Ширээт гүүц «тэнгэрийн мөр», «лха» (тэнгэр), «лам» мөр гэсэн утгатай ахул уг эхийг дагасан гэлтэй, харин аман орчуулгад «лха лам» гэдгийг огторгуй гэж «тэнгэрийн мөр»-ийг нэг үгээр дүйлгэн буулгаж, «мариг»-ийг (мунхаг) 1, (ухамсаргүй) 2, «чүзэн»-г 1 (усан баригч); 2 (үүлэн) гэснээс үзэхэд «номын бие (Дхармакауа) буддийн гүн ухааны үзлээр бурханы 3 биеийн нэг нь билгийн бие, энэ биеийг огторгуйгаар, (мунхаг) буюу ухамсаргүйг хүлээр зүйрлэн билэг ухаанаар хоосон чанарыг ухааран аливаа юм үзэгдлийн мөн чанарыг эндүүрэлгүй мэдээд, эндүүрлийн язгуураас хагацаад билгийн чанадад хязгаарт хүрснийг хэлж буй.

Ширээт гүүш «дод брал» гэдгийн «дод»-ийг (язгуураас) гэж буулгаад «брал»-ыг хагацсан, хоёуланг язгуураас хагацсан, аман судрын ор: чуулгад «дод» (эртэд) гэж буулгаад, «брал»-ыг (ангижирсан) хоёуланг эртэд ангижирсан лүгэ дүйлгэн буулгаж чухам юунаас вэ гэлэл (мунхаг) ухамсаргүйн үүлээс хагацсаныг өгүүлээд энэ 2 орчуулга утгын хувьд дүйх боловч харин судрын аман орчуулгад «эртэд ангижирсан» гэдэг утга тодотгох санааг илэрхийлэхийн хувьд бүр нарийн цаг, орон зай, үйлийн хөдөлгөөн, харьцангуй нэгдэлтэй царцангид бус, эгшин эгшингээр өөрчлөгдөн байдаг жам ёсоор гаргажээ.

Бидний өгүүлэн буй эл зохиолын орчуулгын тухайд өгүүллийн цар хэмжээнээс тэр ажигласан бүгдийг дэлгэрүүлэн нэгтгэж бүхий л талаар энд өгүүлэх хараахан боломжгүй билээ. Харин монголчууд өөрсдөө өнгөрсөн түүхийн суурьтай бат уламжлалт хэлний зүйн байгуулалд нийцүүлсэн мөн найруулга зүйн талаар их нарийн арга байдгийг үгээр үзэж болохоос гадна бичгийн хэлний орчуулга нь Монголынхоо ард түмний эх хэлээ ухамсартай сайхнаар хэрэглэхэд нь үлэмж тус болж, тэрээр өвөр мөц билэг сэтгэгдлийн үзэл, цээжнээсээ нэвтрүүлж, амаар орчуулж байсан зэргийн асуудал нь ард түмний эх хэлийг задлан шинжлэх хэтийн харааг нээгдүүлж байгаа хэрэг.

«Милын намтар»-т Төвдийн тухайн нийгмийн байгуулал, эдийн засгийн хөгжил бадрал, буурал, газар орон, физик газар зүйн нэр ус, цаг уурын нөхцөл, түүхэн хөгжлийн уламжлал, үйлдвэрлэх хүчин, эрхлэн буй аж ахуй, засаг захиргааны байгууламж соёл иргэншил, гадаад дотоод харилцаа, овог аймаг гарвалын асуудал, угсаатны зан заншил, шашин шүтлэг, зан үйл, нийтээр дагаж мөрддөг өвөрмөц ёс, билигших, ёрлох, цээрлэх, хүнийслэх, ураглах, хуримлах зэрэг бүхий л талын асуудлыг сөхөн үзэхэд сонирхолтой материал нэлээд байгаа бөгөөд төвдийн фео-

далын нийгмийн байгууллын зарим талын асуудлыг тодотгон гаргахад чухал хэрэгтэй зохиол юм.

Уг зохиол эхлэхдээ: Мил өөрийн гарвалийн уг шагийг тоочин дурдаж байгаа явдлаар өгүүлэх нь: Төвдийн умарт зүгийн «Врог» их аймаг нэгний дотроос яс Чумбо, язгуур Жосрой, түүний удам дамжлага 7 үе уламжлана.

Ийнхүү тэр язгуурынхаа тухай үгсийг хүмүүсийн хүртээл болгодог байснаас яс, угсаа, овог аймаг удам түүхээ мэдэхгүй хүн нэг ч үгүй байжээ. Нөгөөтэйгүүр эцгийн эрхт ёсны ноёрхол баттай тогтсоных юм. Бас нэгэн зүйл эхийн удам хааяа дурдагдаж байгаа юм.

Эхийн эрхт ёсны зөвхөн үлдэцийн ул тэмдэг цухалзаж буй төдийхнээс үл хэтэрнэ. Энд бас нэгэн баримтыг дурдахад:

Милын эцэг Милицаравжанцан нас барахдаа эхнэр, хүү, охин 3 болон эд хөрөнгө, мал тариаланг авга ах, авга эгч нартаа хадгалуулан гэрээс бичиг үлдээдэг. Энэ чухам юуг харуулж байна вэ? гэвэл, аливаа өв хөрөнгө нь овогтоо үлдэх ба түүнийг эцгийн талын шугамыг баримтлан өвлөдгийг гэрчилж байна. Эдгээр шинж байдлаас нь үзэхүл, Х зууны дунд хагаст төвдийн нийгмийн үндсэн нэгж нь овог байсан ажээ.

Энэ зохиолын төгсгөлийн үгийн талаар зарим нэгэн асуудлыг тодруулан өгүүлэхэд «Егүзэр ясан чимэгт»<sup>5</sup> бичив гэжээ. Энэ зохиол эхлэхдээ Райчундорждагва зүүдээр бичих болсон мэтээр гардаг.

Харин Милын намтрыг Райчундорждагва бичсэн үү, үгүй юу?, хэн бичив гэдэг асуудал тодорхойгүй. Райчундорждагва Милын дэргэд их удаагүй, Энэтхэгт удаан хугацаагаар явж байсан. Харин яагаад төгсгөлийн үгэнд «Ясан чимэгт бичив» гэдэг сонин асуудал юм. Одоо энэхүү өгүүллийн талаар нэгэн шинэлэг тал болох асуудлын талаар хэд хэдэн мэдээ баримтыг ажиглан үзээд уг асуудлыг сөхөн тавихад: Кази Даваасүмдүб Милын намтрыг төвдөөс англи хэлээр орчуулахдаа зарим нэгэн зүйлийг ташааран ухаарсан тал байгаа юм. Милын өвөг эцэг Милдоржсэнгэ худалдааны үүднээс эд хогшил урьдахаас баялаг болсон бөгөөд Заяын дэргэдэх ормаа нэрт орон, нэгэн хүний тариалан шимтэй сайн «дүй сүм», «Гурвалжин» нэгнийг алт зүүн хойт зүгийн эд олноор арилжан авчээ»<sup>6</sup> гэхийг Кази Даваасамдуб энд гарч буй «Ормаа»-г<sup>7</sup> хүний нэр мэт ухаарчээ. Энэ нь хүний нэр биш, газрын нэр болох нь тодорхой байна.

Дашрамд дурдахад, БНХАУ-аас хэвлэн гаргасан Ванфүрэн, Сү вэнчин нарын «Төвд үндэстний түүх» гэдэг номонд Милын намтраас Төвдөд «газар арилжан авдаг» баримт болгон иш татан бичихдээ: «ормаа»<sup>8</sup> гэдгийг хүний нэр гэж давхар ташаарчээ.

«Милын намтар»-ыг бүхэлд нь авч үзвэл Хэл зохиол түүх судлалын ач холбогдолтой бөгөөд түүнээс эртний төвдийн ард түмний амьдрал, соёлын хөгжлийн тухайн үеийн онцлогийг судлахад тус дөхөм болох ажээ.

<sup>5</sup> Милын намтар. 138-р тал, төвд эх судар.

<sup>6</sup> Милын намтар. 9-р тал. Төвд эх судар.

<sup>7</sup> Tibet's Great yogi Milarepa. Biography from the Tibetan Edited by W. V. Evans-ventz, N, Y. 1928 51 тал

<sup>8</sup> Ванфүрэн, Сүвэнчин. «Төвд үндэстний түүх» 54-р тал.